

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2024
ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦСОН НАМ, ЭВСЛИЙН
СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ГНАГ-2024/-15-ШТА-НА/

Мандалговь хот 2025 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох

Утас: 70592439

Аудитын менежер Т.Оюун-Эрдэнэ

Утас: 70592225

Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

Ахлах аудитор Т.Батсайхан

Аудитор Б.Гантуяа

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

Орон нутгийн хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг хянаж, нийтэд мэдээлэх.

АГУУЛГА:

<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Аудитын нэр	2
Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар	Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	2
Дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох	Аудитын зорилго	2
Аудитын менежер	Аудитын хамрах хүрээ	2
Т.Оюун-Эрдэнэ	Арга зүй	2-3
Ахлах аудитор	Үндсэн мэдээлэл	
Т.Батсайхан	Сонгуулийн зардлын дансны орлого, зардал	3-4
Аудитор	Хуулиар зөвшөөрөгдөөгүй хандив:	4-5
Б.Гантуяа	Сонгуулийн зардлын тайланд хийсэн аудитын илрүүлэлт	5
	Хавсралтууд	6-8
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70592208 дугаарын утас, 70592439 дугаарын факсаар харилцана уу.		
ХАЯГ: Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 209 тоот 2024 оны 10 дугаар сар		

Орон нутгийн хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг хянаж, нийтэд мэдээлэх.

СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ**

2025 оны 01 сарын 10 өдөр

Дугаар А/01

Мандалговь

Нийцлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 20 дугаар зүйлийн 20.5, 29 дүгээр зүйлийн 29.4, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов "Эрх шилжүүлэх тухай" 2023 оны А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх"-ийн 1.1, 1.4, Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторов 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн А/27 дугаар тушаалаар баталсан "Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг олон нийтэд мэдээлэх, танилцуулах" журмыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Орон нутгийн хурлын ээлжит сонгуульд оролцох намын сонгуулийн зардлын тайланг хянаж, нийтэд мэдээлэх"-д хийсэн нийцлийн аудитын тайлан /ГНАГ-2024/-12-ШТА-НА/-г нэгдүгээр хавсралтаар, "Орон нутгийн хурлын ээлжит сонгуульд оролцох нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг хянаж, нийтэд мэдээлэх"-д хийсэн нийцлийн аудитын тайлан / ГНАГ-2024/-12-ШТА-НА /-г хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. "Орон нутгийн хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг хянаж, нийтэд мэдээлэх"-д хийсэн аудитын тайланг хуулийн дагуу олон нийтэд мэдээлсүгэй.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Т.Оюун-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.



Р.МӨНХТОГТОХ

20250000014

1. Аудитын нэр

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвслийн сонгуулийн зардлын тайланг баталгаажуулах.

2. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-д “Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ.” гэж заасныг үндэслэн Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар нам, эвслийн сонгуулийн зардлын тайланг хянаж баталгаажуулсан.

3. Аудитын зорилго

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцсон нам, эвслийн төвлөрүүлсэн орлого, иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандив, сонгуулийн зардлыг хянаж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, нийтэд мэдээлнэ.

4. Аудитын хамрах хүрээ

Аудитад аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцсон нам, эвслийн зардлын тайланд хийсэн аудитын дүгнэлт, аудитын дэлгэрэнгүй тайлан, аудит хийгдсэн сонгуулийн зардлын тайлангийн маягтууд, харилцагч банкны дансны хуулга бусад шаардлагатай баримтуудыг хамрууллаа.

5. Арга зүй

Аудитын ажлыг гүйцэтгэхэд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторов 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн А/27 дугаар тушаалаар баталсан “Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг олон нийтэд мэдээлэх, танилцуулах” журмыг үндэслэлээ.

Нэр дэвшигчдийн өөрийн хөрөнгө, нам, эвслээс оруулсан хөрөнгө, иргэн, хуулийн этгээдээс авсан хандив, түүний зарцуулалтын тайланг шалгаж, аудит хийсэн хуулийн этгээд, нам, эвсэл, нэр дэвшигчдээс лавлагаа, тодруулга авч, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж тайланг бэлтгэв.

6. Үндсэн мэдээлэл

Дундговь аймагт аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн 91 тойрогт 2 намын 632 нэр дэвшигч, 13 бие даан нэр дэвшигч, нийт 645 нэр дэвшигч сонгуульд оролцсон байна. Хүснэгт:№1

Д/д	Нам, Эвслийн Нэр	Нам	Эвсэл	Хүснэгт:№1
				Нэр дэвшигчид
1	Монгол Ардын нам	1		316
2	Ардчилсан нам	1		316

Орон нутгийн хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг хянаж, нийтэд мэдээлэх.

3	Бие даан нэр дэвшигч			13
	ДҮН	3		645

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон 2 нам болон тэдгээрийн орон нутаг дахь 30 намын хороод зардлын тайлангаа ирүүлэхээс аудитын хуулийн этгээдээр баталгаажуулж ирүүлсэн байна. Сонгуулийн зардлын хураангуй тайлангаар нийт 9,051.4 мянган төгрөгийн орлого, 9,051.4 мянган төгрөгийн сонгуулийн үйл ажиллагааны зардал, харилцах дансны үлдэгдэлгүй, төлөгдөөгүй өр төлбөргүй тайлагнасан байна.

Сонгуульд оролцсон намууд өөрийн хөрөнгөөс 41.4 мянган төгрөг, 7 иргэн 9,010.0 мянган төгрөг, нийт 9,051.4 сая төгрөгийн мөнгөн хандив өгсөн байна. Үүнээс нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн 5 иргэн нийт 8,010.0 мянган төгрөг хандивласан байна.

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын Тэргүүлэх аудиторын 2024 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн А/15 дугаар тушаалаар Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны ээлжит сонгуульд нам, эвслээс зарцуулах зардлын дээд хэмжээг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд 435.6 сая төгрөг, нэр дэвшигчид тухайн тойргоос хамааран 19.7 сая төгрөгөөс 114.3 сая төгрөгийн хооронд тогтоосон бөгөөд нэр дэвшигчид тогтоосон хэмжээнд зардал гаргажээ.

7. Сонгуулийн зардлын дансны орлого, зардал

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3-д “... Нам эвсэл, санал авах өдрөөс хойш 45 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ.” гэж заасны дагуу 2 намын 32 хороод сонгуулийн зардлын тайлангаа ирүүлсэн байна.

Нийт аудитын хуулийн этгээдээр баталгаажуулсан 32 тайлан ирүүлснээс, 24 зардлын тайлан орлого, зарлага тайлагнаагүй “х” тайлан гаргасан байна.

Намын сонгуулийн зардлын тайлангаарх нийт орлого 9,051.4 мянган төгрөг байна. Сонгуульд оролцсон нам, намын хороодод мөнгөн бус хандив өгсөн иргэн хуулийн этгээд байхгүй байна. /Хүснэгт:№2, Хавсралт:№2/

Хүснэгт:№2

№	ОРЛОГЫН ТӨРӨЛ	Нам, эвслийн орлогын дүн /мянган.төг/				Нийт	
		Тоо	Мөнгөн	Тоо	Мөнгөн бус	Тоо	Мөнгөн
1	Нам, эвслээс оруулсан мөнгөн хөрөнгө	5	41.4			5	41.4
2	Иргэний хандив	7	9,010.0			7	9,010.0
	ДҮН	12	9,051.4	-	-	12	9,051.4

Нам, эвсэл сонгуулийн үйл ажиллагааны зардалд нийт 9,051.4 мянган төгрөг зарцуулснаас сонгуулийн зардалд 9,010.0 мянган төгрөг, бусад зардалд 41.4 мянган төгрөгийг зарцуулжээ. /Хүснэгт:№3, Хавсралт: №3/

Хүснэгт:№3

Орон нутгийн хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг хянаж, нийтэд мэдээлэх.

№	Зардлын төрөл		Нам, эвслийн зардлын дүн /мянган.төг/
ЗАРДЛЫН АНГИЛАЛ НИЙТ ЗАРДЛЫН ДҮН			9,051.4
2.1	Сонгуулийн зардлын дүн		9,010.0
	2.1.1	Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах	-
	2.1.2	Нийтийн эзэмшлийн гудамж талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар, дэлгэц байрлуулах	-
	2.1.3	Намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал	-
	2.1.4	Сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал-Шатахуун	-
	2.1.5	Сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал /Урамшуулал/	8,907.6
	2.1.6	Сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах зардал	-
	2.1.7	Цахим орчин ашиглах зардал	102.4
	2.1.8	Өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд материал нийтлүүлэх зардал	-
2.2	Бусад зардлын дүн		41.4

Намын сонгуулийн зардлын тайлангаар урамшууллын зардалд 8,907.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

8. Хуулиар зөвшөөрөгдөөгүй хандив

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон орон нутаг дахь 32 намын хороодын дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй хандив ороогүй байна. Мөн хандивын хууль бус зарцуулалт хийгдээгүй байна.

9. Сонгуулийн зардлын тайланд хийсэн аудитын илрүүлэлт:

Аудитын хуулийн этгээд нь Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторов 2024 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн А/31 дугаар тушаалаар баталсан “Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг олон нийтэд мэдээлэх, танилцуулах” журмын дагуу аудит хийж баталгаажуулсныг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар дахин хянахад алдаа зөрчил илрээгүй.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.5-д “Сонгуулийн зардлын данс байршуулсан банкны захирал, эсхүл салбарын эрхлэгч уг дансны бүх гүйлгээний хуулгыг гаргаж, санал авах өдрөөс хойш 30 хоногийн дотор төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлнэ.” заасны дагуу намын хороодын сонгуулийн зардлын дансны хуулгыг ХААН, Төрийн болон Хас банкууд хугацаандаа ирүүлсэн байна.

10. Аудитын дүгнэлт

Орон нутгийн хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг хянаж, нийтэд мэдээлэх.

Аудитын хуулийн этгээд Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон орон нутаг дахь 32 намын хороодын сонгуулийн зардлын тайланг үнэн зөв, иж бүрэн илэрхийлэгдсэн гэж дүгнэлт гаргажээ.

Орон нутгийн хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг хянаж, нийтэд мэдээлэх.

ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТУУД

Орон нутгийн сонгуульд нэр дэвшсэн нэр дэвшигчид 1 сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэдийн жагсаалт

Хавсралт № 1

/мянган төгрөг/

№	Сум дүүрэг	Хандив өгсөн этгээдийн овог нэр	Регистр	Мөнгөн дүн
1	Луус сумын Ардчилсан намын хороо	Л.Цолмон	3361010517	2,000.0
2	Луус сумын Ардчилсан намын хороо	Б.Цогбаяр	3358111509	1,000.0
3	Луус сумын Ардчилсан намын хороо	Б.Лхагвасүрэн	3398012126	1,000.0
4	Өндөршил сумын Ардчилсан намын хороо	Д.Оюунчимэг	3В76072861	2,010.0
5	Сайхан-Овоо сумын Ардчилсан намын хороо	Ө.Эрдэнэтөгс	483420290495	2,000.0
	Нийт дүн			8,010.0

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвслийн сонгуулийн зардлын санхүүжилт

Хавсралт: №2

/мянган төгрөг/

№	Сум, дүүрэг	Нийт орлогын дүн	Үүнээс:					
			Нам, эвслээс оруулсан мөнгөн хөрөнгө	Нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө	Хуулийн этгээдийн		Иргэний	
					Тоо	Өгсөн хандив	Тоо	Өгсөн хандив
1	Дундговь аймгийн Ардчилсан намын хороо	0.5	0.5	-	-	-	-	-
2	Говь-Угтаал сумын Ардчилсан намын хороо	20.0	20.0	-	-	-	-	-
3	Дэлгэрцогт сумын Ардчилсан намын хороо	0.3	0.3	-	-	-	-	-
4	Луус сумын Ардчилсан намын хороо	5,000.0	-	-	-	-	5	5,000.0
5	Өндөршил сумын Ардчилсан намын хороо	2,010.0	-	-	-	-	1	2,010.0
6	Сайнцагаан сумын Ардчилсан намын хороо	0.3	0.3	-	-	-	-	-
7	Сайхан-Овоо сумын Ардчилсан намын хороо	2,000.0	-	-	-	-	1	2,000.0
8	Цагаандэлгэр сумын Ардчилсан намын хороо	20.3	20.3	-	-	-	-	-
	Нийт дүн	9,051.4	41.4	-	-	-	7	9,010.0

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвслийн сонгуулийн зардлын зарцуулалт

Хавсралт №3

/мянган төгрөг/

№	Сум, дүүрэг	Нийт Зардлын дүн	2.1									2.2
			Сонгуулийн зардлын дүн	2.1.1	2.1.2	2.1.3	2.1.4	2.1.5	2.1.6	2.1.7	2.1.8	Бусад зардлын дүн
				Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах	Нийтийн эзэмшлийн гудамж талбайд сонгуулийн сурталчил- гааны зурагт самбар, дэлгэц байрлуулах	Намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг уриа ашиглах зардал	Сонгогчид- той уулзалт, хурал, цуглаан хийх зардал- Шатахуун	Сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал /Урамшуулал/	Сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах зардал	Цахим орчин ашиглах зардал	Өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд материал нийтлүүлэх зардал	
1	Дундговь аймгийн Ардчилсан намын хороо	0.5	-	-	-	-	-	-	-	-	-	0.5
4	Говь-Угтаал сумын Ардчилсан намын хороо	20.0	-	-	-	-	-	-	-	-	-	20.0
6	Дэлгэрцогт сумын Ардчилсан намын хороо	0.3	-	-	-	-	-	-	-	-	-	0.3
7	Луус сумын Ардчилсан намын хороо	5,000.0	5,000.0	-	-	-	-	5,000.0	-	-	-	-
9	Өндөршил сумын Ардчилсан намын хороо	2,010.0	2,010.0	-	-	-	-	1,907.6	-	102.4	-	-
10	Сайнцагаан сумын Ардчилсан намын хороо	0.3	-	-	-	-	-	-	-	-	-	0.3
11	Сайхан-Овоо сумын Ардчилсан намын хороо	2,000.0	2,000.0	-	-	-	-	2,000.0	-	-	-	-

Орон нутгийн хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг хянаж, нийтэд мэдээлэх.

1	Цагаандэлгэр сумын	20.3	-	-	-	-	-	-	-	-	-	20.3
2	Ардчилсан намын хороо											
		9,051.4	9,010.0	-	-	-	-	8,907.6	-	102.4	-	41.4